

Г. Сүхбаатар

Манай улсад Өвөр Монголын автономит район (дүүрэг) гэж албан ёсны хятад нэрийг баримтлан зөв нэрлэж байснаа сүүлийн жилд өвөрлөгчид өөрсдөө нэрлэдгээр Өвөр Монголын өөртөө засах орон гэх болсон юм. 1991 онд Хөх хотод хятад хэлээр нийтлэгдсэн «Нэймэнгу да цыдянь» (Өвөр монголын том толь) гэдэг 1000 гаруй хуудастай гарын авлага лавлахыг ашиглан энэхүү товч лавламжийг хийв.

Өвөр Монгол захиргааны талаар 8 аймаг, 17 хот, 17 сянь (гацаа), 51 хошуу, 3 автономит хошуу, 16 хотын харьяаны дүүрэг болж хуваагдана. Үүнд:

1. Хөх хот нь Түмэд зүүн хошуу, Тогтох сянь, хотын Юйцюань дүүрэг, Шинэ хот дүүрэг, Хуй (хотон) угсаатны дүүрэг, Хотын захын дүүрэг, Циншань дүүрэг, Дунхэ дүүрэг, Шигуай уурхайн дүүрэг, Баян-

2. Бугат хот нь Түмэд баруун хошуу, Гуян сянь, хотын Хөндлөн дүүрэг, Циншань дүүрэг, Дунхэ дүүрэг, Шигуай уурхайн дүүрэг, Баян-овоо уурхайн дүүрэг, хотын захын дүүрэг гэх 1 сянь, 1 хошуу, 6 дүүрэг байна.

3. Ухай хот нь Хайбовань дүүрэг, Уда дүүрэг, Хайнань дүүрэг гэх 3 дүүрэг байна.

4. Улаан хад (Чифэн) хот нь Нинчэн дүүрэг, Линьси дүүрэг, Аохань хошуу, Харчин хошуу, Онниуд хошуу, Хишигтэн хошуу, Баарин зүүн хошуу, Баарин баруун хошуу, Архорчин хошуу, хотын Хуншань дүүрэг, Юаньбао дүүрэг, хотын захын дүүрэг гэх 2 сянь, 7 хошуу, 3 хотын дүүрэг байна.

5. Хөлөнбуйр аймаг нь Хайлар хот, Манжуур хот, Якэши хот, Жалантун хот, Өргөнө зүүн хошуу, Өргөнө баруун хошуу, Шинэбарга Зүүн хошуу, Шинэбарга баруун хошуу, Ажун хошуу, Чэнь барга хошуу, Орчунь автономит хошуу, Эвэнки угсаатны автономит хошуу, Мориндаваа дагур автономит хошуу гэх 4 хот, 6 хошуу, 3 автономит хошуу байна.

Г. Сүхбаатар — Зүүн хойт Ази судлалын төвийн тэргүүлэх ажилтан, түүхийн ухааны доктор.

6. Хянган аймаг нь Улаан хот, Туцюань сянь, Жалайд хошуу, Хорчин баруун гарын дундад хошуу, Хорчин баруун гарын өмнөд хошуу гэх 1 хот, 1 сянь, 3 хошуу байна.

7. Жирэм аймаг нь Гунляо хот, Хэлиньголә (Хэрингол) хот, Кайлусянь, Найман хошуу, Жаруд хошуу, Хүрээ хошуу, Хорчин зүүн гарын дундад хошуу, Хорчин зүүн гарын хойд хошуу гэх 2 хот, 1 сянь, 5 хошуу байна.

8. Шилийн гол аймаг нь Шилин хот, Эрээн (Эрлян) хот, Долунь сянь, Абага хошуу, Зүүн үзэмчин хошуу, Баруун үзэмчин хошуу, Сөнөд зүүн хошуу, Сөнөд баруун хошуу, Тайбус хошуу, Чжэнлан хошуу, Чжэнсянбай хошуу, Сянхуан хошуу гэх 2 хот, 1 сянь, 9 хошуу байна.

9. Улаанцав аймаг нь Цзинин хот, Фэнчжэнь хот, Синхэсянь, Шанду сянь, Циншуйхэ сянь, Учунан сянь, Лянчэн сянь, Хорингэр сянь, Чжозы сянь, Хуадэсянь, Цахар баруун гарын дундад хошуу Цахар баруун гарын хойд хошуу, Сыцзы (дөрвөн хүүхэд) вангийн хошуу, Дархан муумянганы нийлсэн хошуу, Цахар баруун гарын өмнөд хошуу гэх 3 хот, 8 сянь, 5 хошуу байна.

10. Ихзуу аймаг нь Дуншэн хот, Зүүнгар хошуу, Хангин хошуу, Далад хошуу, Эзэн хороо хошуу, Урад дундад хошуу, Ушин хошуу, Отог хошуу, Отог өмнөд хошуу гэх 1 хот, 7 хошуу байна.

11. Баяннуур аймаг нь Линьхэ хот, Уюань сянь, Дэнкоу сянь, Хангин хойд хошуу, Урад өмнөд хошуу, Урад дундад хошуу, Урад хойд хошуу гэх 1 хот, 2 сянь, 4 хошуу байна.

12. Алаша аймаг нь Алаша Зүүн хошуу, Алаша баруун хошуу, Эзэн хошуу гэх 3 хошуу байна.

Өвөрмонголын өөртөө засах орон нь 1947 оны 5-р сарын 1-нд Улаан хотод байгуулагдсан бөгөөд зүүн талаараа Амар мөрөн (Хэйлунцзян), Цилинь, Ляонин, 3 мужтай, өмнөд талаар Хэбэй, Шаньси, Шэньси, 3 муж, Нинсягийн Уйгурын автономит дүүрэгтэй, баруун талаар Гансу мужтай залгаж, хойд талаар Холбоот Орос улс, Монгол улстай хиллэдэг. Хилийн шугамын нийт урт нь 4221 км. 1 сая 183000 хавтгай дөрвөлжин км нутагтай. Энэ нь БНХАУ-ын нутгийн 12,3% болно. 1990 оны хүн амын 4 дэх удаагийн тооллогоор 21 сая 456800 хүнтэй, 49 угсаатнаас бүрдэнэ. Нийт хүн амын 80,6% буюу 17 сая 298700 нь хятад, 15,7% буюу 3 сая 375200 нь монгол, 3,7% буюу 782900 нь бусад угсаатан юм. Тэмдэглүүштэй нь уг толины хавсралтанд (977) хүн амын тоог арай зөрүүтэй дурдсан, үүнд нийт хүн ам 21 сая 626000, үүнээс 15,7% буюу 3 сая 410000 нь монгол гэжээ. Нэг хавтгай дөрвөлжин км² нутагт 18,3 хүн оногдоно. Манж нар 1664 онд одоогийн Өвөрмонголын нутгийг эзлэн аваад уг нутгийн монголчуудыг өвөр (дотоод) монголчууд гэж нэрлэсэн нь одоо ч хэрэглэгдсээр байна. 1570—1582 оны үед баруун, зүүн талын монголчууд 1 сая 90000 байсан бол Манж Цин улсын үед шарын шашин дэлгэрэн, монголын хүн амын өсөлтөнд нөлөөлж, 1736—1795 он болоход монголын хүн ам 1 сая 30000 болон хорогдсон. Үүний дараачийн зуу гаруй жилийн дотор 1 сая 30000 байснаа 829000 болон хорогджээ гэж толь бичигт (51-р тал) монголын хүн амын түүхийн талаар сонин баримт дурдсан байна.

Захиргааны төв нь Хөх хот юм. Хөх хотыг Түмэдийн Алтан (1507—1581) хаан 1581 онд эхлэн байгуулсан, үүнийг одоо хувчин хот гэнэ. Манж нар 1735—1739 онд цэргийн хороолол шинээр барьсныг шинэ хот гэнэ. 6100 км² талбай эзэлнэ. Хотын хүн ам 1441600, үүнээс 9,2% буюу 132700 нь монголчууд юм. Хөх хотод аж үйлдвэр түргэн хөгжиж, ноосон нэхмэл, машины үйлдвэрийн төв болжээ. 1989 онд хотын аж үйлдвэрийн нийт бүтээгдэхүүн 2415000000 юань хүрсэн байна.

Бугат хот 9991 км талбайтай, 1779300 хүн амтай, түүний 35000 буюу 0,19% нь монголчууд, Бугат Өвөрмонголын хамгийн олон хүнтэй, үйлдвэрийн түвшин хамгийн өндөр, эдийн засаг, шинжлэх ухааны боловсон хүчин хамгийн хүчтэй нэгдүгээр зэргийн хот юм. Бугатын болдын үйлдвэр нь нийт улсын болд төмрийн алдартай үйлдвэрийн газар юм. Хотын аж үйлдвэрийн нийт бүтээгдэхүүн 1988 онд 3770000000 юань болжээ.

Ухай нь 2350 км² талбайтай, 314000 хүн амтай, түүний 2,7% буюу 8600 нь монголчууд. Одоо Ухай нь нүүрс, барилгын материал, хими, цахилгаан эрчим хүч голлосон үйлдвэртэй. 1988 онд аж үйлдвэрийн нийт бүтээгдэхүүн 468,14 сая юань хүрсэн.

Улаанхад хот 84000 км² талбайтай, 4105800 хүнтэй, түүний 1,6% буюу 677000 нь монголчууд.

Хөх хот, Бугат, Ухай, Улаанхад нь гацаа, хошуу бүхий захиргааны нэгж хот мөн болохоор харьяа гацаа, хошууны нутаг, хүн амыг хамардаг юм. 1989 онд хотын аж үйлдвэр, хөдөө аж ахуйн нийт бүтээгдэхүүн 3 тэрбум юань хүрчээ.

Хөлөнбуйр аймаг нь манай Дорнод аймагтай хиллэнэ. 250000 км² нутагтай, 2551800 хүн амтай, түүний 7,2% буюу 185400 нь монголчууд байна. 1990 оны сүүлчээр мал, гахай нь 2755000 толгой байсны 1570000 нь хонь, 401000 нь гахай байна. Голлон усан тутрага, эрдэнэ шиш, буудай, шар буурцаг зэрэг тариална. 1990 онд хүнсний зүйл 1201989 тонн болсон. Нүүрс, машин техник, цахилгаан эрчим хүч, барилгын материал, хими, ноос, арьс, шир зэрэг үйлдвэртэй.

Хянган аймаг Дорнод аймагтай зурвас газраар хиллэнэ. 59800 км² нутагтай, 1524100 хүн амтай, түүний 38% буюу 588000 нь монголчууд. 1990 оны сүүлчээр мал, гахай 2589000 толгой байснаас 1320000 нь хонь юм. Голлон эрдэнэ шиш, буудай, усан тутрага, төмс, шар буурцаг, шиш зэргийг тариалдаг. 1990 онд хөдөө аж ахуйн бүтээгдэхүүн нь 1214385100 юань хүрсэн. Болд төмөр багаж хэрэгсэл зэрэг үйлдвэртэй. 1989 онд аж үйлдвэрийн бүтээгдэхүүн 451000000 юань хүрсэн байна.

Шилийн гол аймаг нь манай улсын Сүхбаатар, Дорноговь аймагтай хиллэнэ. 200600 км² нутагтай, 888000 хүн амтай, түүний 28,7 буюу 255000 нь монголчууд байна. Гол мал нь үхэр, адуу, хонь. Талын улаан үхэр, өвөрлөгчийн нарийн ноост хонь, үзэмчин өөхөн сүүлт хонь, сөнөд хонь мэтийн үүлдрийн мал байдаг. 1990 оны сүүлчээр 8204300 малтай болсон, үүнээс 6816800 нь хонь байна. Мал аж ахуйн бүтээгдэхүүн нь 722466700 юань болжээ. Тус аймгийн нутгийн өмнөд талаар буудай, сагаг буудай, юмай буудай, нариму, төмс тариална. 1990 онд хүнсний зүйлийн үйлдвэрлэл 189756 тонн болж, хөдөө аж ахуйн үйлдвэрлэл 1032540000 юань хүрчээ. Мал аж ахуйн бүтээгдэхүүн, давс, шүлт, шүү боловсруулалт, нүүрсний үйлдвэр голлодог. Газрын тос (нефть) ашиглаж эхэлсэн. 1989 онд аж үйлдвэрийн нийт бүтээгдэхүүн 265000000 юань хүрчээ. Шилин, Эрээн гэх хоёр хот бий. Эрээн (Эрлян) гэдэг манай улстай харилцах хилийн боомт дүүргийн хамт 162 км² дэвсгэр нутагтай, 11600 хүн амтай, түүний 12,9% буюу 1500 нь монголчууд юм. Уг нь Сөгөдийн баруун гар хошууны харьяа нутаг юм. 1956 оны 9-р сард Эрээн боомт бий болж, 1966 онд Сөнөдийн баруун гар хошуунаас салж хот болсон. 1969 оны 12-р сараас 1980 оны 5-р сар хүртэл Улаанцав аймгийн харьяалалд байсан. 1990 онд хөдөө аж ахуйн бүтээгдэхүүн нь 1412700 юань хүрсэн. Тус хотод химийн үйлдвэр, хайлуур жоншны уурхай, арьс, ноос, оёдлын үйлдвэр зэрэг бий.

Улаанцав аймаг манай улсын Дорноговь аймагтай хиллэнэ. 84700 км² нутагтай, 3171300 хүн амтай, түүнээс 2,6% буюу 84300 нь монголчууд юм. Буудай, юмай буудай, нариму, төмс зэргийг голлон тариална. 1990 онд хүнсний зүйлийн үйлдвэр 1194799 тонн болсон. 1990 оны сүүлчээр 5129000 толгой малтай байсны 4051000 нь хонь юм. Нүүрс, машин техник, барилгын материал, бордоо, махан бүтээгдэхүүн боловсруулах, арьс шир, хивс зэрэг үйлдвэр бий. 1989 онд аж үйлдвэрийн нийт бүтээгдэхүүн 671000000 юань хүрчээ. Улаанбаатараас Бээжин хүрэх замд Цзинин хот байдаг. Захын дүүрэгтэйгээ 125 км² дэвсгэр нутагтай, 193100 хүн амтай, түүний 3,6% буюу 7000 нь монголчууд юм.

Баяннуур аймаг манай улсын Дорноговь, Өмнөговь аймагтай хиллэнэ. 64400 км² дэвсгэр нутагтай, 1562600 хүн амтай, түүний 4,1% буюу 65600 нь монголчууд юм. Буудай голлон тарихын зэрэгцээ эрдэнэ шиш зэргийг тариална. 1990 онд хүнсний бүтээгдэхүүн 959857 тонн болсон. 1990 оны эцсээр 4471000 толгой мал байсны 3670000 нь хонь юм. Цахилгаан эрчим хүч, машин техник, чихэр, цаас, ноос арьс, хивс зэргийн үйлдвэртэй, 1989 онд аж үйлдвэрийн нийт бүтээгдэхүүн 630000000 юань болжээ.

Алаша аймаг манай Монгол улсын Өмнөговь, Баянхонгор, Говьалтай аймагтай хиллэнэ. 270000 км² нутагтай, 165600 хүн амтай, түүний 2,5% буюу 42000 нь монголчууд юм. Эдийн засаг нь мал аж ахуй юм. 1990 оны сүүлчээр 1425000 толгой малтай, түүний 1235000 нь хонь, 145000 нь тэмээ. Буудай, нариму, эрдэнэ шиш зэрэг тариална. 1990 онд хүнсний зүйл 29857 тонн хүрчээ. Ноос, арьс боловсруулах, хивс, цемент, барилгын материал зэрэг үйлдвэрийн газар бий. 1989 онд аж үйлдвэрийн нийт бүтээгдэхүүн 201000000 юань хүрчээ.

Жирэм аймаг нь Өвөрмонголын зүүн хэсэгт оршино. 59500 км² дэвсгэр нутагтай, 2753700 хүн амтай, түүний 42,5% буюу 1160900 нь монголчууд юм. Эрдэнэ шиш, шиш, нариму, шар буурцаг, төмс, буудай зэргийг тариална. 1990 онд хүнсний зүйл 2423442 тонн болжээ. 1990 оны сүүлчээр 4871000 толгой мал байсны 819000 нь үхэр 2031000 нь хонь, 1459000 нь гахай юм. Мал аж ахуйн бүтээгдэхүүн 8794000 юань хүрчээ. Эрчим хүч, машин техник, хими, барилгын материал, ноосон нэхмэл, сүү, мах боловсруулах, цаас, чихэр хэвлэх зэрэг үйлдвэртэй 1989 онд аж үйлдвэрийн нийт бүтээгдэхүүн 21460000 юань хүрчээ.

Ихзуу (их сүм) аймаг нь Өвөрмонголын баруун өмнө хэсэгт оршино. 86400 км² дэвсгэр нутагтай, 1198900 хүн амтай, түүний 11,7% буюу 141000 нь монголчууд юм. Лагшим будаа, нариму, сагаг, төмс зэргийг голлон тариална. 1990 онд хүнсний зүйлийн үйлдвэрлэл 15653 тонн хүрч, хөдөө аж ахуйн нийт бүтээгдэхүүн 45618000 юань болжээ. Чулуун нүүрс, ноосон нэхмэл, барилгын материал, хими, эм, цаас зэрэг үйлдвэр бий. 1989 онд аж үйлдвэрийн бүтээгдэхүүн 156003000 юань хүрчээ.

Өнөөдрийн Өвөрмонголын өөртөө засах оронд хүн амын дийлэнхи олонхи (80,6%) болон хятад үндэстэн нутаглан суудаг болохоор нийт хүн амын харилцааны хэл нь хятад хэл байна. Хөх хотод нийтлэгдсэн «Монгол хэл бичиг» сэтгүүлийн 1980 оны 4-р сарын 12-р талд бичсэнээр монголоор ярьдаг хүн 1 сая орчим хүн байдаг гэнэ. Иймд өвөрмонголчуудын олонхи нь хятад-монгол хэл мэддэг буюу монгол хэл мэддэггүй хүн байдаг юм байна.